


Салан баавгайн үлгэр

Дасгал 1

Сонсоод, үлгэрийн утгыг ойлгоорой



Араатан баавгай анд явжээ

Анд яваад аргаль барьжээ

Барьсан аргалиа

Баруун сугандаа

Бат хавчуулжээ

Буцаж яваад

Буга барьжээ

Буга бариад

Буруу сугандаа

Бултрахгүй хавчуулжээ

Орой болоход

Оготно барьжээ

Оготно бариад

Олзуурхаж аваад





Баруун сугандаа

Бас хавчуулжээ

Бас хавчуулахдаа

Анх хавчуулсан

Аргалиа гээжээ

... Ичээ нүхэндээ

Ирээд үзвэл

Хоёр суга нь

Хоосон байжээ

Хамгийн сүүлд

Хар шоргоолж

Хамж хавчуулсан нь

Хаягдсан байжээ

... Салан баавгайн үлгэрийг


Санаж яваарай багачууд аа

Эхлээд сурснаа гээлгүй

Эргэж давтаж яваарай!

Дасгал 2


Баавгайн агнасан анг үлгэрт гарч буй үйл явдлын дарааллаар зөөн, дугаарын ард байрлуулаарай



Буга барьжээ



Оготно барьжээ.



Аргаль барьжээ.



Шоргоолж барьжээ.

Дасгал 3

Өгөгдсөн үгэнд тохирох нөхцөл залгаж бичээрэй

	Өгөгдсөн үг	-ын	-ийн	-ы	-ий	-н
1	буга	ын	ийн	ы	ий	н
2	аргаль	ын	ийн	ы	ий	н
3	баавгай	ын	ийн	ы	ий	н
4	үлгэр	ын	ийн	ы	ий	н
5	шоргоолж	ын	ийн	ы	ий	н
6	ичээ	ын	ийн	ы	ий	н
7	араатан	ын	ийн	ы	ий	н
8	оготно	ын	ийн	ы	ий	н
9	барьсан	ын	ийн	ы	ий	н
10	гээсэн	ын	ийн	ы	ий	н
11	сурсан	ын	ийн	ы	ий	н
12	хаягдсан	ын	ийн	ы	ий	н

Дасгал 4

Амьтдын хийдэг үйлийг зөв сонгоно уу.

1. Буга
2. Оготно
3. Чоно
4. Мэлхий



Дасгал 5

Үлгэрийг дахин сонсоод, хоосон зайд утга тохирох үгийг сонгон байрлуулаарай

Орой болоход	барьжээ.
Хамгийн сүүлд	барьжээ.
Анд яваад	барьжээ.
Буцаж яваад	барьжээ.

шоргоолж

буга

оготно

аргаль

Дасгал 6

Бичлэгийг үзээд, баавгай зурж сураарай

Дасгал 7

Үеэр зөв тасалсан үгийг зөв сонгож, тэмдэглэ (✓)

А.

үл-гэр

үлгэр

үлг-эр

Б.

оготно

огот-но

о-гот-но

В.

арга-лиа

аргалиа

ар-га-лиа

Дасгал 8

Төлийнх нь нэрийг зургийн доор зөөж тавиарай



хурга

гүег



илий

алманцаг

Дасгал 9

Зөв бичсэн үгийг сонгоорой

барь

сур

хаягд

хавчуул

Дасгал 10

Эхийг уншаад, сорилын зөвийг тэмдэглээрэй

Баавгайт нутгийн баатарлаг явдал

Анчид ид өвлөөр баавгай боорлуулахаар мордоцгооно. Даваа гүвээг цас хунгарлан боосон байдаг. Түүнийг модон түншүүрээр балбан нунтаглана. Ингэхийг бамбардах гэнэ.

Ийнхүү өндөр давааг давна. Анчид баавгайг хаана ичихийг андахгүй. Ичээ рүү нь шургааг мод зөрүүлэн баавгай хахуулийн хажуугаар чихэлдэн гарч ирэхэд, модны зөрсөн ац хоолойд нь тээглээд урагш ахиулахгүй. Тэр үед ичээний шил дээр зогсох анчин цохонд нь тулган буудна.

Үхэж байгаа баавгай хэчнээн муухай орилно гээч!

Араа шүд нь ярзайн, амь тавин чарлахад, морьд айснаасаа болж цусаар шээдэг гэлцдэг.

Анчин бол үүнийг тэсч чадна.

- Сорилын зөв хариултыг тэмдэглээрэй

Өндөр өндөр давааг хэрхэн давдаг вэ?	Модоор цохиж давна	Бамбардаж байж давна	Галаар бамбардаж байж давна	Цасыг нунтаглаж байж давна
Анчид баавгайн ичээ хаана байдгийг хэр мэдэх вэ?	сайн мэдэхгүй	эрж олдог	сайн мэддэг	мэддэг
Баавгай яагаад ичээнээс гарч чаддаггүй вэ?	анчдаас айгаад	модноос айгаад	модонд тээглээд	Модны хажуугаар багтахгүй